



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/9/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [ariunaa.ch@audit.gov.mn](mailto:ariunaa.ch@audit.gov.mn)

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг: [kherlenchimegch@audit.gov.mn](mailto:kherlenchimegch@audit.gov.mn)

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020 Цахим хаяг: [uranbileg.b@audit.gov.mn](mailto:uranbileg.b@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	4
2. Аудитын тайлан .....	6
2.1. Оршил.....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө .....	8
2.8.3 Авлага.....	9
2.8.6 Бараа материал .....	9
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	10
2.8.8 Өр төлбөр .....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	24
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	25
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	28
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	29

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.03.25 № 1-6/367  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Д.ДУЛАМ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дэлгэрэх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

### 1. Санхүүгийн байдлын тайланд:

Сум хөгжүүлэх сангийн олгосон 107.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 2. Анхан шатны баримт бүрдэл:


ЗДТГ нь байгууллагын даргын буюу 1-р гарын үсэг, тамга тэмдэг, төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй төлбөрийн хүсэлтээр нийт 23.9 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, харилцах дансны хуулгаар 9.1 сая төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн боловч холбогдох төлбөрийн хүсэлт, анхан шатны баримт байхгүй байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 37.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.7, Засгийн газрын 2015 оны 24-р тогтоолын 7.5, 8.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2. Аудитын тайлан

---

### 2.1. Оршил

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Дулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 23-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг гүйцэтгэв.

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03/79 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг

гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 2685.8 сая төгрөгийн 1 хувь буюу 26.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 2775.3 сая төгрөгийн 1 хувь буюу 27.8 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатны материаллаг түвшнийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, тусгайн сангийн 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллага 2 сан аудитад хамрагдаж, 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сан түүвэрт хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвд “Зөрчилгүй”, Засаг даргын тамгын газарт “Хязгаарлалттай” дүгнэлтүүдийг өгсөн байна.

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 453.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 140.4 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 140.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 168.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлээ. Аудитаар өгсөн зөвлөмжийн 172.7 сая төгрөгийн зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг бус зөрчил тул зөрчлийн дүнгээс хасч материаллаг байдлын түвшинг тооцлоо.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 140.4 сая төгрөгийн залруулга хийлээ.

- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага болох 107.8 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүйг тооцоолол хийж залруулав.
- Орон нутгийн хөгжлийн сангийн буцаж орсон 0.4 сая төгрөгийн гүйлгээг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснийг залруулав.
- СХС-ийн санхүүгийн үр дүнгийн тайланг 32.2 сая төгрөгийн алдаатай, буруу тайлагнасныг залруулав.

## **2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

### **2.8.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 82.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 85.7 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	82.6	85.7	3.1	3.8
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>82.6</b>	<b>85.7</b>	<b>3.1</b>	<b>3.8</b>

*Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ОНХС-ийн 3.9 сая төгрөг, СХС-ийн 67.1 сая төгрөг, НСС-ийн 13.7 сая төгрөг, нэмэлт дансны санхүүжилтийн үлдэгдэл төвлөрүүлсэн 1.0 сая төгрөгийн үлдэгдэл тус тус тайлагнагдсан байна.

*Илрүүлэлт: Сумын Засаг даргын тамгын газрын дарга болон төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдэггүй төлбөрийн хүсэлтээр 23.9 сая төгрөгийн, 9.1 сая төгрөгийн гүйлгээний төлбөрийн хүсэлт анхан шатны баримтгүй байна.*

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 126.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 109.5 сая төгрөг болж, 17 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.7	1.4	-0.3
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	0.2	0.4	0.2
Зээлийн авлага	124.6	107.8	-16.8
<b>Дүн</b>	<b>126.5</b>	<b>109.5</b>	<b>-17</b>

*Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын 98.4 хувь нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага байна.

*Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.*

## 2.8.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 232.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 255.3 сая төгрөг болж, 23.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+/ бууралт/-/
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>232.3</b>	<b>255.3</b>	23
<b>Түүхий эд материал</b>	<b>9.9</b>	<b>19.9</b>	10
Тусгай зориулалттай материал	8.1	8.1	0
Эм боох материал	1.8	11.8	10
<b>Хангамжийн материал</b>	<b>220.3</b>	<b>233</b>	12.7
Бичиг хэргийн материал	6.2	15.6	9.4
Аж ахуйн материал	162	172.3	10.3
Сэлбэг хэрэгсэл	0.3	1.8	1.5
Түлш, шатах тослох материал	33.3	23.5	-9.8
Барилгын засварын материал	0.5	0.5	0
Хүнсний материал	14.4	15.4	1
Бусад хангамжийн материал	3.6	3.9	0.3
<b>Мал амьтад</b>	<b>2.1</b>	<b>2.4</b>	0.3

*Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

*Илрүүлэлт: Засаг даргын тамгын газар 21.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг холбогдох тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд, 4.3 сая төгрөгийн материалыг бараа материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардалд тус тус бүртгэж тайлагнасан байна.*

## 2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2273.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2314.1 сая төгрөг болж, 40.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>2273.9</b>	<b>2314.1</b>	<b>40.2</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>2175.8</b>	<b>2215.9</b>	<b>40.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	1404.4	1429.9	25.5
Хуримтлагдсан элэгдэл	-0.3	-56.4	-56.1
Авто-тээврийн хэрэгсэл	236.6	273.5	36.9
Хуримтлагдсан элэгдэл	-158.2	-206.1	-47.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	404.0	452.1	48.1
Хуримтлагдсан элэгдэл	-260.1	-294.3	-34.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	124.9	173	48.1
Хуримтлагдсан элэгдэл	-75.1	-90.4	-15.3
Бусад үндсэн хөрөнгө	1139.1	1251.1	112
Хуримтлагдсан элэгдэл	-669.1	-754.9	-85.8
Ном	28	35.8	7.8
Түүх соёлын дурсгалт зүйл	1.6	2.6	1
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>98.1</b>	<b>98.2</b>	<b>0.1</b>
Програм хангамж	1.7	2.1	0.4
Хасагдуулга	-1.5	-1.8	-0.3
Бусад биет бус хөрөнгө	97.9	97.9	0

*Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө: Төсвийн хөрөнгөөр 52.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 227.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар авсан байна.

## 2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.6 төгрөг, эцсийн үлдэгдэл 6.2 сая төгрөг болж, 2.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	1.2	4.1	2.9	70.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	<b>1.9</b>	<b>1.0</b>	-0.9	47.3
Бусад өглөг	<b>0.5</b>	<b>1.2</b>	0.7	58.3
<b>Дүн</b>	<b>3.6</b>	<b>6.2</b>	2.6	

*Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр нь богино хугацаат өр төлбөр байна.

## 2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2711.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2758.4 сая төгрөг болж, 46.7 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1149.0	1149.0	0	0
Хуримтлагдсан үр дүн	942.8	986.3	43.5	4.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619.9	623.1	3.2	0.5
<b>Дүн</b>	<b>2711.7</b>	<b>2758.4</b>	<b>46.7</b>	

Эх сурвалж: Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 2.9 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дэлгэрэх сумын ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай тогтоолоор тайлант онд 43.1 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 57.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 14.3 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Үйл ажиллагааны орлогын албан татвар	27.8	32.1	4.3	115.5
2	Бусад татвар	1.1	8.3	7.2	754.5
3	Бууны татвар	1.7	1.4	-0.3	82.4
4	Улсын тэмдэгтийн хураамж	3.9	3.5	-0.4	89.7
5	Хог хаягдал үйлчилгээний хураамж	2.7	2.1	-0.6	77.8
6	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.06	1.3	1.2	2166.7
7	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	0.3	0.3	0	100.0
8	Хадгаламжийн хүүгийн орлого	5.3	8.2	2.9	154.7
10	Хүү торгуулийн орлого	0.2	0.2	0	100.0
	Нийт орлого	43.1	57.4	14.3	133.3

Орлогын төлөвлөгөө давсан нь дараах шалтгаантай байна.

- Хадгаламжийн хүүгийн орлого тухайн жил зээл буурч, хадгаламж өссөнөөр 2.9 сая төгрөгөөр;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр сумын төвд спорт соёлын төв баригдаж байгаатай холбоотой гүйцэтгэгч байгууллагатай гэрээ хийснээр 1.2 сая төгрөгөөр давсан нь улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламжийн элс хайргыг орон нутгаас бэлтгэсэнтэй холбоотой байна.

- Үйл ажиллагааны орлого арьс шир, ноосны урамшуулал олгосноор 4.2 сая төгрөгөөр;
- Бусад татвар сугалаатай холбоотойгоор 7.2 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Орлогын төлөвлөгөө тасарсан нь дараах шалтгаантай байна.

- Бууны албан татвар иргэний эзэмшлийн буу хасагдсанаар 0.3 сая төгрөгөөр;
- Улсын тэмдэгтийн хураамжийн төлөвлөгөөт орлого нь банкны зээл олголт бага байгаатай холбоотойгоор 0.4 сая төгрөгөөр;
- Хог хаягдлын хураамжийн төлбөр уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулаагүйгээс 0.6 сая төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлого улсын байцаагчийн эрхгүйгээс 0.2 сая төгрөгийг бүрдүүлээгүй байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 29 хөтөлбөрт зориулан 1633.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 105.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1528.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1007.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 514.3 орон нутгийн төсвөөс сая төгрөгийг, 18.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 92.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1000.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 511.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18.6 сая төгрөгийг, нийт үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 22.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 22.0 сая төгрөгийг бүрдүүлсэн. Орлогын төлөвлөгөөнд сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн сангийн дансны үлдэгдлийн дүнгээр дараа онд санхүүжих дүнг төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд сумын ОНХС-ийн хөрөнгөөр шинээр 7 ТАХ-г тайлант онд 105.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор, төлөвлөж, гүйцэтгэлээр 100.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 13.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12.8 сая төгрөг, нийт 26.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, зарцуулсан байна.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 24.1 сая төгрөг, тэтгэвэр тэтгэмж зардалд 1.4 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 0.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлтийн үйл ажиллагааг авч үзэх.

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 157 мэдээллийг байршуулахаас 97 хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

### 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай дүгнэлт”

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, сангуудын залруулагдаагүй зөрчлийн дүнг нэгтгэн үзэхэд 313.5 сая төгрөг байх бөгөөд нийт залруулаагүй алдаа зөрчлийг 140.8 сая төгрөгөөр тооцож бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс их байх тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>441,438,727.83</b>	<b>450,549,170.57</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>82,618,001.00</b>	<b>85,650,556.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>82,618,001.00</b>	<b>85,650,556.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>82,618,001.00</b>	<b>85,650,556.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	82,618,001.00	85,650,556.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>126,478,799.39</b>	<b>109,532,324.24</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,654,827.00	1,360,232.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>188,600.00</b>	<b>354,053.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	183,200.00	348,653.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,400.00	5,400.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>124,635,372.39</b>	<b>107,818,039.24</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>124,635,372.39</b>	<b>107,818,039.24</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	124,635,372.39	107,818,039.24
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>232,341,927.44</b>	<b>255,366,290.33</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>9,938,897.68</b>	<b>19,944,082.68</b>
35110	Тусгай зориулалттай материал	8,096,596.00	8,100,596.00
35130	Эм боох материал	1,842,301.68	11,843,486.68
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>220,343,029.76</b>	<b>232,977,207.65</b>
35410	Бичиг хэргийн материал	6,234,215.00	15,596,979.00
35420	Аж ахуйн материал	162,046,582.51	172,302,410.00
35430	Сэлбэг хэрэгсэл	255,600.00	1,755,600.00
35440	Түлш, шатах тослох материал	33,252,990.15	23,462,690.15
35450	Барилгын засварын материал	500,000.00	500,000.00
35460	Хүнсний материал	14,369,244.10	15,447,230.50
35470	Бусад хангамжийн материал	3,684,398.00	3,912,298.00
35600	Мал амьтад	2,060,000.00	2,445,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,273,934,987.39</b>	<b>2,314,165,002.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,273,934,987.39</b>	<b>2,314,165,002.82</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,175,876,987.67</b>	<b>2,215,960,002.82</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,404,394,397.00	1,429,835,597.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.02	-56,397,676.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	236,635,060.00	273,505,060.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-158,225,672.66	-206,096,753.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	404,049,050.49	452,063,550.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-260,095,343.80	-294,297,931.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	124,864,171.20	173,043,815.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,060,208.20	-90,350,240.92
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,569,800.00	2,669,800.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,139,147,896.30	1,251,122,078.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-669,136,213.74	-754,891,168.96
39217	Ном	27,984,051.10	35,753,872.10
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>98,057,999.72</b>	<b>98,205,000.00</b>
39301	Програм хангамж	1,724,000.00	2,054,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,574,000.28	-1,757,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	97,908,000.00	97,908,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,715,373,715.22</b>	<b>2,764,714,173.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,591,254.00</b>	<b>6,274,825.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,591,254.00</b>	<b>6,274,825.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>3,591,254.00</b>	<b>6,274,825.00</b>

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,158,865.00	4,123,922.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,910,600.00	908,673.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>521,789.00</b>	<b>1,242,230.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	472,760.00	1,173,203.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	49,029.00	69,027.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,711,782,461.22</b>	<b>2,758,439,348.39</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,711,782,461.22</b>	<b>2,758,439,348.39</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,149,032,382.70	1,149,032,382.70
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>942,845,198.51</b>	<b>986,282,597.38</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,263,406,175.19	929,592,510.21
51220	Тайлант үеийн үр дүн	-320,560,976.68	56,690,087.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619,904,880.01	623,124,368.31
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,715,373,715.22</b>	<b>2,764,714,173.39</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,661,759,543.44</b>	<b>1,715,648,260.32</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>35,653,887.98</b>	<b>48,929,220.96</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>25,348,157.98</b>	<b>40,458,128.96</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>25,348,157.98</b>	<b>40,458,128.96</b>
110002	Үйл ажиллагааны орлого	1,162,070.00	0.00
110004	Хөрөнгө борлуулсны орлого	436,800.00	0.00
110008	Шууд бус орлого	23,749,287.98	40,458,128.96
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>1,912,000.00</b>	<b>1,469,000.00</b>
113002	Бууны албан татвар	1,912,000.00	1,469,000.00
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>8,393,730.00</b>	<b>7,002,092.00</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>8,393,730.00</b>	<b>7,002,092.00</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,189,730.00	3,583,092.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100,000.00	1,300,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,104,000.00	2,119,000.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>101,223,751.46</b>	<b>146,930,410.36</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>101,223,751.46</b>	<b>146,930,410.36</b>
120002	Хүүгийн орлого	0.00	8,257,447.71
120003	Торгуулийн орлого	6,429,010.00	0.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>94,794,741.46</b>	<b>138,672,962.65</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,438,500.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	820,000.00	385,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,789,114.07	133,146,663.80
1200046	Зээлийн хүүгийн орлого	6,747,127.39	4,541,298.85
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,524,881,904.00</b>	<b>1,519,788,629.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>961,069,400.00</b>	<b>1,003,416,962.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	886,456,200.00	902,725,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	74,613,200.00	100,691,162.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,820,031.00</b>	<b>26,433,077.00</b>

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,670,031.00	13,575,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000.00	12,858,077.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>544,992,473.00</b>	<b>471,346,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	291,508,400.00	114,512,500.00
